

*Дээрхийн Гэгээнтэн 14 дүгээр Далай багшийн  
туурвисан Зона ринбүүчи ламтаны*

*“Түргэн залрах соёрхол айлтгал” оршвой*

Бурхан, бодисадва, ширваган, брадигабудын чуулган  
Богд лам сайн оюут эцэг хөвүүдийн дамжлага сэлт  
Бус маш олон ертөнцийн авралт орон хоцролгүй бүгд  
Бултаар эдүгээ энд ерөөл бүтэхийн сайн буяныг хайрла.

Огоот төгс **Чадагчийн** дээд **шашин** эрдэнийг  
Онц номлол бүтээлийн үйлээр барин арвитгахад  
Огт үл шантрах **хүлцэнгүйн** бат хөө хуягтан  
Ор адилтгаш үгүй гэтэлгэгч багшид залбирмуй.

Ямагт тус амгалан хоцрол үгүй гарахын гагц үүдэн  
Ялгуусны шашин эрдэнэ хийгээд эх болсон амьтны тусад  
Ялгамжит хичээнгүйг буцалтгүй зохион туурвиж ахуй үестээ  
Яаран гэнэт амарлин ажирсанд сэтгэл ихэд гансарвай.

Хэдий тийм ч гурван эрдэнийн далай мэт үлэмж адистид  
Хэтэрхий ялгуусны хөвүүдийн үүсгэсэн агуу их таалал  
Хуурмаггүй үнэнээр шинэд хувилж мишээн гийгүүлэхийг  
Хувь сайт шавь нарын цог буянд түргэнээ бадруулан  
зохиотугай.

хэмээх үүнийг ханьцашгүй ихээр шашныг гийгүүлэгч Зона  
ринбүүчи гэнэт амирлалд ажирсан буйд түргэн залрах  
ерөөлийн үг нэгэн хэрэгтэй хэмээн Рожер Гүнсан тэргүүлсэн  
“FRMT” Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах нийт төвийнхөн  
болоод Гопан Огминжанчүв чойлин хийд, Хажид гачиллин  
хийд, түүнчлэн оронд ажирсан ринбүүчийн нийт шавь нараас

сануулснаар нөхцөлдөн мөн Ринбүүчи сэрүүн тунгалаг ахуйдаа өөрийн их, бага ажил үйлүүдээ надаас асуун лавлаж хийдэг байсан гэх мэт нийтийн бус барилдлагатай байсан учир энэ түргэн залрах ерөөлийн үгийг найрууллаа. Зопа ринбүүчи ийн ажирсан нь харамсалтай ч гол нь эрхэм тэрээр лагшин тунгалаг үедээ эрдэнэт бодийн сэтгэлийг анхааран авлагын төв болгон зохиодог байсан учир ард үлдсэн даган суралцагчид нь ч мөн багшийнхаа тэрхүү намтарт ёсчлон суралцвал Ринбүүчийн таалал түүгээр бүрэн хангагдах нь магадтай учир тэр хэргийг сэтгэлдээ хадгалан авна уу!

Эндээс ч гурван эрдэнэд соёрхол талбих хийгээд зориулга ерөөлийг хичээнгүйлэн үйлдмүй.

Шагжийн аяга тахимлага, номыг өгүүлэгч Далай лам бээр 17-р жарны усан туулай жилийн 2-р сарын 25, нийтийн тооллын 2023 оны 4-р сарын 15-нд найруулав.